



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон, 25,320,487.50 (хорин таван сая гурван зуун хорин мянга дөрвөн зуун наян долоон төгрөг тавин мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашины 3 дахь дуудлагын худалдааг зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн захирал Д.Мандахад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагад төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.03.06\togtool\04docx

0001497

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
 48... дугаар тогтоолын хавсралт



Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
 дахин нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ	ТӨБЗГ-ын 2017 оны 442 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ
				/төгрөг/		
1	Тоёота виндом, УБӨ-5222, суудлын, Арал: JT160002365	2002/2007	230,000	25,320,487.50	2,000,000.00	1,000,000.00
Нийт дүн				25,320,487.50	2,000,000.00	1,000,000.00
				(хорин таван сая гурван зуун хорин мянга дөрвөн зуун наян долоон төгрөг тавин мөнгө)	(хоёр сая)	(нэг сая)